| Д/д | Оролцогчийн тодруулга | Захиалагчийн хариулт |
|---|---|---|
| 1 | Цахим системд "Техникийн санал бэлтгэх" болон "Санхүүгийн санал бэлтгэх" хэсгүүд байна. Иймд тендерийн баримт бичгийг техникийн санал болон санхүүгийн санал гэсэн 2 хэсэгт бэлтгэх шаардлагатай эсэх?<br>Хэрэв 2 хувь санал бэлдэх шаардлагатай бол техникийн санал болон санхүүгийн саналын материал нь ямар шаардлагыг хангасан байх шаардлагатай вэ?<br>Хэрэв 1 хувь санал бэлтгэх шаардлагатай бол "Санхүүгийн санал бэлтгэх" хэсэгт хураалгах уу? | Цахим системийн "Техникийн санал бэлтгэх" хэсэгт тухайн тендер шалгаруулалтад илгээхээр бэлтгэсэн тендерийн материалыг хавсаргана .<br>"Санхүүгийн санал бэлтгэх" хэсэгт санал болгож буй унийн саналын мэдээллийг холбогдох талбарт оруулж, тендер илгээх үйлдлийг хийнэ. |
| 2 | Бидэнд тендерийн баталгаа бичгийг гаргаж өгдөг банкнаас хариу ирсэн байна: Тендерийн баталгаа нь шилжүүлэгтэй холбоотой тул SWIFT системийг ашиглах шаардлагатай, Дэлхийн банк хоорондын санхүүгийн харилцаа холбооны нийгэмлэг. Гэвч, уг систем нь төслийн дугаар "НХААG/20240103208" т байгаа монгол үсэг "НХААГ"-ийг дэмждэггүй. Иймд танай талаас дараах зүйлийг тодорхойлж өгнө үү,<br>1. Swift системд монгол үсэг "НХААГ"-ийн оронд англи үсэг "NHAAG" -ийг орлуулан ашиглахыг зөвшөөнө үү;<br>2. Swift системд зөвхөн төслийн дугаар 20240103208 ашиглахыг зөвшөөнө үү;<br>3. Эсвэл тань талаас бусад хувилбар байгаа бол бид түүнийг хэрэгжүүлэх болно. | Тендерийн баталгааны маягтын тендер шалгаруулалтын дугаар заавал кирилл үсгээр байх шаардлагагүй. |
| 3 | Гадаадын банкнаас гаргасан тендерийн банкны баталгааг яаж баталгаажуулах вэ? | Гадаад улсын банкны баталгааг бүртгэх харилцааг Сангийн сайдын 2023 оны А/252 дугаар тушаалаар батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-аар зохицуулсан бөгөөд журмын 4.3, 4.3.1, 4. 3.2-т заасны дагуу Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан цахим системд илгээнэ. Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллага журмын 4. 3.2-т заасныг хэрэгжүүлэхэд техникийн шийдлээс шалтгаалан цахим системд илгээх боломжгүй бол Төрийн худалдан авах ажиллагааны газарт хандаж, дэмжлэг авах боломжтой. |